

## FICHE EXPLICATIVE SCANNER EN MONGOL



### СКАНЕР ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

#### Сканер гэж юу вэ ?

шинжилгээ нь цацрагийн туяаны идэвхжлийг ашиглан хүний бие организмын доторхи эрхтнүүдийн хэсэгчлэн зүссэн зургийг авах боломж олгодог нарийн шинжилгээ юм. Уг зургууд нь маш нарийвчлан гардаг бөгөөд миллиметрын өөрчлөлтийг олж харах чадалтай.Сканер нь цацрагийн туяаг ашигладаг.

**Шинжилгээний явц** Үзлэг нь хэвтээ байдалд явагддаг бөгөөд хүний биеийг тусгай зориулалтын цагираган аппаратанд оруулах боломжтой тусгай орон дээр дээшээ харсан байдалтайгаар хийгддэг. Та шинжилгээний өрөөнд оруулж байрлуулсны дараагаар та ганцаараа үлдэх ба эмч техникч нар шилэн цонхны цаана байрлах болно, тэд шинжилгээний явцанд тантай тусгай микрофоны тусламжтайгаар ярилцах боломжтой.Таны туслалцаа үүнд маш чухал.Та биеэ хөдөлгөөнгүй байлгах хэрэгтэй ба бид танд амьсгалаа түр барих хэрэгтэйг микрофоноор хэлж мэдээлнэ. Зарим тохиолдолд шинжилгээний үед судсаар тариа хийх хэрэг гардаг ба уг тохиолдолд таны тохойн нугалаасанд хэвтээ байдал эзлэхийн өмнө жижиг зүү байрлуулдаг.Тарих тарианы найрлага нь йодын хольцтой бодис болно. Тариа хийх явцад өвдөлт өгөхгүй бөгөөд заримдаа халуун оргиж буй мэт санагдах эсвэл аманд сонин амт амтагдаж магадгүй.Шинжилгээний хугацаа богино, 5 –15 минут үргэлжилнэ.

**Таны шинжилгээний дараа мөрдөх дэглэм**Тусгай дэглэм байдаггүй ба та шинжилгээ дуусмагц жирийн маягаар хоолож болно.

#### Ямар хүндрэл учирч болох вэ?

Хүний бие организмд хийгддэг бүх төрлийн үзлэг шинжилгээ нь нарийн мэргэжлийн хамт олноор хийгдэж буй ч гэсэн хүндрэл гарах боломжтой байдаг.

Уг шинжилгээний хүндрэлүүд нь шинжилгээтэй холбоотой бус харин хийгдсэн йодын бодистой холбоотой байдаг. Үүнд:Тариаг хийхэд бага зэргийн цус хуралт үүсэж магадгүй, гэвч тэр нь хэдэн хоногийн дараа арилдаг.Тариа хийх явцад уг тариа нь арьсан дор тархах хүндрэл гарч болзошгүй. Энэ хүндрэл нь маш ховор бөгөөд гадны эмчилгээ шаарддаг.Харшил ба йодын хольцтой бодисыг хүлээж авах чадвар буурах урвал өгж болзошгүй. Гэхдээ энэ нь нь хүнд хүндрэл бус түр зуурынх бөгөөд хурдан арилдаг. Маш ховор үед зүрх судасны үйл ажиллагааг хамарсан хүндрэл учирч болох бөгөөд тэр нь тусгай эмчилгээ шаарддаг. Амь алдах хүндрэл маш ховор тохиолддог бөгөөд тэр нь 1 00 000 тохиолдолд нэг удаа тохиолддог байна (энэ тоо нь замын аваргийн тоогоос хамаагүй бага юм)Өвчтөн бөөрний ямар нэгэн өвчтэй байвал, жишээ нь сахарын шижин, бөөрний архаг дутагдал г.м. урьдчилсан эмчилгээ сувилгаа хийх шаардлага гардаг.



## FICHE EXPLICATIVE SCANNER EN MONGOL

### Доорхи асуултуудыг бөглөнө үү

Та доорхи асуултуудад хариулна уу:

1. Та сүүлийн үед контраст бодис хэрэглэн хоолны замын шинжилгээ хийлгэсэн үү? Тийм  Үгүй
2. Та эмийн харшилтай юу?
  - Эмийн харшил бий юу? Тийм  Үгүй
  - Та астм – гуурсан хоолойн багтраа өвчинтэй юу? Тийм  Үгүй
  - Та өмнө ямар нэгэн шинжилгээний үед харшил өгж байсан уу? Тийм  Үгүй
3. Та диабет – сахарын шижин өвчтэй эсвэл Та Метформин (METFORMINE) эмийг хэрэглэдэг үү? Тийм  Үгүй
4. Та жирэмсэн уу эсвэл жирэмсэн байх магадлалтай юу? Тийм  Үгүй   
Та хүүхдээ хөхүүлж байгаа юу? Тийм  Үгүй
6. өөрийн мэдэх бөөрний дутагдалтай юу? Тийм  Үгүй
7. Та судсанд контрастын бодис тариулахыг зөвшөөрч байна уу? Тийм  Үгүй

Ноен, ХатагтайӨөрийн биеэр уг хуудсыг он сар өдөрбөглөсөн  
бөгөөд шинжилгээ хийх зөвшөөрлийг өгсөн болно

**Гарын үсэг :**

**Хуулийн байгууллагын гарын үсэг :**(насанд хүрээгүй хүүхдүүдэд)